

Хиад Дашдондог Энхбат

*МУИС-ийн ГХСС-ийн багш,
Хэл шинжлэлийн ухааны доктор (PhD)*

Б. Мягмарсайхан

Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийн багш

НИЙГЭМ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН СУДАЛГААНЫ ГОЛ ХАНДЛАГА, ЧИГЛЭЛ

Abstract: *Language is a complicated business. In everyday talk, we use the word “language” in many different ways. Sociolinguistics is that branch of linguistics which studies just those properties of language and languages which require reference to social, including contextual, factors in their explanation. Some investigators have found it appropriate to try to introduce a distinction between sociolinguistics or micro-sociolinguistics and the sociology of language or macro-sociolinguistics. In this distinction, sociolinguistics is concerned with investigating the relationships between language and society with the goal being a better understanding of the structure of language and how languages function in communication.*

Key words: *socio-linguistic research, principles, definitions, concepts.*

Хүмүүс хамтран амьдрах болсон тэр цагаас өөрсдийн харилцан ярилцагч дохионы хэрэглүүр болох авиан хэлний мөн чанар, хэл хэзээ яаж үүссэн, хэл сэтгэцийн хэлхээ холбоо, нийгмийн хүчин зүйл хэл- сэтгэцийн шүтэлцээ зэргийг ажиглан судалсаар иржээ. Хэл шинжээчид хэлний үүсэл гарал, төлөвшил, өөрчлөлт хувьслын гол хүчин зүйл нь хүмүүний нийгэм хэмээн үзэж улмаар хэлийг нийгмийн талаас нь судлах болжээ. Аливаа хэлний хэлний баримт, байдал, өөрчлөлт зэргийг нийгмийн үзэгдлийн хувьд судалсан түүх эрт үеэс эхтэй хэмээн үзэж болох боловч 17 –р зууны эхэн үеэс л хэлний өөрчлөлтийг ажиглан дүгнэн үлдээжээ. Тухайн хэлээр ярилцагчдын хэл нь нийгмийн нийт гишүүдийн хувьд харилцан адилгүй, зарим талаар ялгаатай байдгийг ажиглан тэмдэглэсэн байдаг. Тухайлбал 17 зууны эхэн үед Испаний Саламандын Их сургуулийн профессор **Гонсало де Корреас** “Тухайн орон нутагт ярилцагч гол хэл аялгуутай хамт эл нутагт амьдарч оршин суугчдын нас, нийгмийн байдал, хөрөнгө чинээ зэрэгтэй холбоотой хэл аялгуу байдаг: тодруулбал хөдөө тосгоны оршин суугчид, энгийн ард иргэд, хотын иргэд, сурвалжит ихэс дээдэс, түүхч эрдэмтэд, өтгөс өвгөд, шашины номлогч, эмэгтэйчүүд, эрчүүд, тэр ч бүү хэл хүүхэд багачуудын хэл яриа байдаг аж. “хэмээн хэлэхүйн төрөл зүйлийг тодорхойлсон байдаг.

Америкийн социологч **Н. Currie** [“*A projection of socio- linguistics :the relationship of speech to social status// Southern Speech Journal. Vol 18 .195 2 ' 1*] бүтээлдээ **нийгэм хэлшинжлэл** буюу “**sociolinguistics**” хэмээх нэр томъёог анх хэрэглэн хэл шинжлэлийн эргэлтэнд оруулсан эрдэмтэн хэмээн зүй ёсоор тооцдог юм. Мөн 18-19 зууны заагт Франц утга зохиолын хэлийг **Пол Лафарг** “Хэл ба хувьсгал” [1894] зохиолдоо марксист байр сууриас судалжээ. Уг бүтээлдээ францын хөрөнгөтний хувьсгал зэрэг нийгмийн хүчин зүйл хэлэнд хэрхэн нөлөөлсөн хийгээд тэдгээр нь хэлэнд хэрхэн илэрснийг судалжээ. Социологийн хандлагын үүднээс хэлний байдал, өөрчлөлт хувьслыг судлах нь зайлшгүйг эрдэмтэн судлаачид нэг бус удаа тэмдэглэж байсан боловч хэлний нийгмийн тодорхойлолтыг гол төлөв гүн ухааны, сэтгэл судлалын болон нийгэм судлалын ойлголт, нэр томъёогоор л илэрхийлж байв. XX зууны хэл шинжлэлийн хөгжлийн явцад хэлний бүтцийн хандлагаас нийгмийн талыг зааглан тусгаалан судлах болсон юм. Хэл шинжээч **Фердинанд де Соссюр** анх хэл/ франц- *la langue*, хэлэхүй буюу / *la parole* /, хэлэх үйлийг / *la language*/ хэмээн зааглан хэлийг **дотоод - гадаад хэл шинжлэл** гэсэн хосмогт судалсан юм. Тэрбээр гадаад хэл шинжлэл хэмээх ойлголт дор угсаатанзүйтэй холбоотой аливаа ойлголт, хэлний өөрчлөлт хөгжлийн түүх, үндэстэн угсаатны хэл аялгуу, соёл иргэншлийн түүхэн хөгжил зэргийг хам хийгээд цуваа цагт судалж болохыг дурдсан байдаг.

Ф.Соссюр гадаад хэл шинжлэлд үндэстэн угсаатны хэлээс гадна олон хэл аялгуу үүсэн гарсан хийгээд тэдгээр нь хэрхэн тархсан зэргийг оруулан судлахын чухлыг онцолсон. Хэл шинжлэл дахь социологийн дэг сургуулийн гол төлөөлөгч, Ф.де Соссюрын шавь **А.Мейе** болон түүнийг залгамжлагчид аливаа хэлийг судлахад нийгмийн талыг зайлшгүй тооцон үзэхийн чухлыг онцолсон нь хэлийг судлах нийгэм хэлшинжлэлийн шинэ чиглэл болсон байна. Тэрбээр хэлний нийгмийн талыг (хүчин зүйл) түлхүү судлахыг чухалчилж үгийн сангийн утга өөрчлөгдөх гол шалтгаан нь “*нийгмийн амьдралд гарсан аливаа өөрчлөлт, хүчин зүйл*” хэмээн үзсэн байна. А.Мейе тухайн хэлний үгийн сангийн утгын агууламж, хэлзүйн дүрмийн өөрчлөлт зэрэг нь соёл иргэншлийн хөгжилтэй холбоотой хэмээн үзэж үүнийгээ энэтхэг европын хэлний дүрмийн хүйсийн утга, нөхцлийн балархайшил, хэлзүйн бүтцийн хураангуйлал зэргээр жишээ татан тайлбарлажээ. Хожим нь уг санааг судлаач хөгжүүлж **А.Соммерфельт** “*Хэл хийгээд нийгэм*” [1938] бүтээлдээ хэлний хэв шинж, нийгмийн байгуулал болон хүмүүсийн сэтгэлгээ хоорондоо хамааралтай эсэхийг судалж түүнийгээ австралын “*аранта*” омог болон америкийн уугаал оршин суугчдын хэлний баримтаар батлахыг оролджээ. XX зууны 20-30 аад оны үед Прагийн хэл шинжлэлийн дэгийн төлөөлөгчдын дэвшүүлсэн “утга зохиолын хэлний онол” нь нийгмийн хэл шинжлэлд шинэ урсгал болсон хэмээн үздэг юм. []

Эрдэмтэн **В.Гавранек** зохиол бүтээлдээ утга зохиолын хэл нь “*тодорхой нийгмийн хэрэгцээ тэй уялдаатай тухайн хэлний оршин байх хэлбэр*” хэмээн тодорхойлсон. Судлаач **Р.О.Якобсон** Дэлхийн хоёр дайны хоорондох үеийн европын хэлшинжлэлийг ерөнхийлөн дүгнэж Прагын дэг нь “хэлийг харилцааны чухал хэрэглүүр, нийгмийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэгч “*хэрэглүүр*” хэмээн үзлээс үүдэн гарах “хэлний зорилтот загварыг бий болгох эрмэлзлэл” –ээрээ ялгардаг хэмээн дүгнэсэн байдаг. [] Лейпцигийн дэг сургуулийн төлөөлөгч болох **Теодор Фрингсийн** туурвисан германы түүхэн аялгуу судлалын зохиол бүтээл нийгэм хэлшинжлэлд тодорхой хувь нэмэр оруулсан хэмээн үздэг. Судлаач “*Герман хэл шинжлэл хийгээд аялгуу судлал*” бүтээлдээ “авиа, залгавар, үг бүтэх ёсон, өгүүлбэрийн бүтэц зэрэг нь бие хүн хийгээд нийгмийн амьдралд гарсан бүхий л өөрчлөлт хувьсалтай холбоотой болохыг тайлбарлажээ. Үүний сацуу хэлний үзэгдэлд газарзүй болон түүхийн үзэгдэлд хэрхэн нөлөөлсөн зэргийг судалжээ. Уг судалгаандаа Франц улстай хиллэдэг Рейн мөрөн хавийн уулархаг нутгийнхны аялгын эртний хэлбэр нь дундад зууны үеийн Германы өмнөд хийгээд умард аялгаас онцлог байгааг тэмдэглэн уг аялгууны гийгүүлэгчийн өөрчлөлт нь олон зууны явцад аажим гарч 1500 оны үед төлөвшжээ. хэмээн үзжээ. ()

20 – зуунд Оросын эрдэмтэн **И.А.Бодуэн де Куртене, Е.Д.Поливанов, Л.П.Якубский, В.М.Жирмундский, Б.А.Ларин, А.М.Селишев, Г.О.Винокур**, францын эрдэмтэн **Шарль Балли, Ф.Брюно, П.Лафарг, М.Коэн**, швейцарын **А.Сешез**, бельгийн **Ж.Вандриес**, чехийн **А.Матезиус** нарын зохиол бүтээлд нийгэм хэлшинжлэлийн чиг хандлага үндсэндээ тусгай судлагдахуун болж төлөвшжээ. Судлаач **Ш.Балли** хэлний хэрэглүүр нь харилцах хүрээний хувьд нийгмийн давраажилтай холбоотой байдгийг онцолсон бол оросын судлаачид хэлний хувьсал өөрчлөлт нь нийгмийн амьдралд гарсан аливаа өөрчлөлтийг тусгадаг хийгээд хэлний хувьсал нь нийгмийн хүчин зүйлтэй нягт шүтэлцээтэйг харгалзан үзэх нь чухлыг онцолж байв.

Оросын нийгэм хэлшинжлэл 20 - р зууны 20-30 оны үеэс хэлний нийгмийн талын чиглэлийн төлөөлөгчид болох **Р.О.Шор, Е.Д.Поливанов, К.Н.Державин, Б.А.Ларин, М.В.Сергеевский, М.Н.Петерсон, Л.Я.Якубинский, Н.М.Каранский, В.М.Жирмунский, А.М.Селишев, В.В.Виноградов** нарын бүтээлд олон хэлний баримтанд тулгуурлан нийгэм хэлшинжлэлийн үндсэн зорилго, зорилт зэргийг бүтээлдээ тодорхойлжээ. Тухайлбал **Р.О.Шор** “*Хэл хийгээд нийгэм*” / 1926/ бүтээлдээ хэл –нийгмийн шүтэлцээний талаар нягтлан судалсан бол **Е.Д.Поливанов** бичсэн өгүүлэлдээ “хэлний шинжлэх ухаан нь байгальтүүхийн төдийгүй нийгмийн талыг судалдаг байх хэрэгтэй хэмээн бичсэн байдаг. [] **Б.А.Ларин** “*хотынхны хэл яриа*”- нь утга зохиолын хэл болон тосгоны хэл аялгуунаас ялгаатай байдлыг судлахыг дэвшүүлсэн. Мөн **В.М.Жирмунский** “*Үндэсний хэл хийгээд нийгмийн аялгуу*” зохиолдоо орос болон европын хэлүүд, түүний дотор герман хэлний баримтанд тулгуурлан зөвлөлтийн хэл шинжлээчдийн нийгэм хэл шинжлэлийн салбарын судалгааг дүгнэжээ. Нийгэм хэл шинжлэлд дараах гурван зүйлд анхаарал хандуулбал зохистойг онцолсон байдаг. Үүнд :

- Нийгмийн хувьсал өөрчлөлт хэлэнд илрэн гарах хэлбэр,

- Хэлэхүйн тодорхой хэв шинж үүсэн төлөвших хэлбэр,
- Нийгмийн х үчин зүйлийн нөлөөгөөр хэл өөрчлөгдөн хувьсахтай уялдаатай хэлний дотоод бүтцийн өөрчлөлт зэрэг болно

XX зууны 60 – аад оноос Америкийн хэл шинжлэлтэн нар уугаал оршин суугчдын олон хэл аялгуу, тэдгээрийн бичиг үсгийн өвийг судлахдаа нийгмийн талыг анхаарах болсон нь *“sociolinguistics”* буюу нийгэм хэлшинжлэл хэмээх салбар төлөвшин гарсны нотолгоо болсон гэж үздэг юм.[] Уг нэр томъёог судлаач **Х.Карри** /*H.C. Currie* /1952 онд судалгааны эргэлтэнд оруулсан хийгээд хэл шинжлэлд шинэ ойлголт хэмээн хэрэглэгдэж байв. Энэ нь нэг талаар хэдийгээр уг салбарын нэр шинээр тогтоогүй байсан хэдий ч хэлийг нийгмийн хүчин зүйлийн талаас нь судлах нь бодит хэрэгцээ болсныг харуулсан байна.. Судлаач **Д.Хаймс** 1969 онд Рим хотод болсон Нийгэм хэлшинжлэлийн Анхдугаар конгрессд тавьсан илтгэлдээ нийгэм хэлшинжлэлийг европын хэлний зорилгын загвар/ *means- ends modell*/ болон Эдуард Сепирийн үзэл баримтлалыг хослуулсан салбар судлагдахуун хэмээн тодорхойлсон байдаг. Энэ үеийн америкийн хэл шинжлэлд хоёр хандлага байсан хэмээн судлаачид онцолдог. Үүнд:

- *Судалгааны гол судлагдахуун нь “хэл - өөрөө юм” хэмээн үздэг чиглэл* / В.Лабов, Ж.Гамберц нар/ Нью Йорк хотынхны хэлний давхраажилыг судалсан нэг сэдэвт бүтээлдээ В.Лабов хэлэхүйн нийгмийн ялгарамжийн талаар өөрийн судалсан хэлний баримтанд тулгуурлан өдөр тутмын харилцааны бодит дүр зургийг судалж хэлэхүйн өөрчлөлт нь *“ хэлний өөрийн дотоод тогтолцоо төдийгүй нийгэм хэлшинжлэлийн гадаад орчны өөрчлөлттэй холбоотой “* гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Судлаач Ж.Гамберц хэлэхүйн нөхцөл байдлыг судлан онолын үндсэн баримтлалаа / постулат/ бичил бөлгийн онол ,нийгмийн харилцан үйлдлэлийн онол болон үүргийн онолд тулгуурлан хэлний хэлбэрийн хувилбарыг нийгмийн нөхцөл байдалтай уялдуулсан байдаг. Тэрбээр дараах хоёр хэлний байршлын / *distribution* / хэлбэрийг онцлон үзжээ Үүнд : “тодорхой нэгэн бие хүний хэл аялга нь тухайн нийгмийн буюу газар нутгийн харилцаагаар ялгагдах хэлбэр, нийгмийн бүлгүүдийн хооронд гарах хэл аялгын / бие хүн хоорондын/ болон тухайн хэлний хамтлагийн аялганы хэм хэмжээ нь аажимдаа өдөр тутмын энгийн хэл ярианы хэм хэмжээ болон цаашилбал утга зохиолын хэлний хэм хэмжээнд нөлөөлөх нөхцөл байдал болдог: тодруубал тэр бие хүн нь нэг зэрэг тухайн хэлний хамтлагийн дотор орших нийгмийн олон давхраа ны төлөөлөгч болон хэлэхүйн олон төрлийг тээгч болдог байна. Үүнийг “ялгарах буюу бие хүий дотоод ялгарамж”/ *variation* /хэмээн нэрлэсэн.[]
- *Угсаатанзүйн чиглэл – буюу хэлэхүйн угсаатанзүйн чиглэл* / *ethnography of speaking* /энэ нь харилцахуйн нөхцөл байдал, хэлэх үйл ,загвар зэргийг судлах явдал юм. Судлаач **Д.Хаймс** /*D.H.ymes* / хэлний харьцангуй шинж буюу нийгмийн шүтэлцээг болон хэлэхүйг угсаатанзүй талаас судлахыг зорьсон болно. Тэрбээр **Э.Сепир, Б.Уорф** нарын “*Хэлний харьцангуй шинжийн онолд тодорхойлсон “ янз бүрийн хэлээр ярилцдаг нийгмийн байгуулал оршин тогтнож байгаа ертөнц гэдэг бол хэрэг дээрээ өөр өөр ертөнц болохоос биш янз бүрээр нэрлэсэн нэг ертөнц биш юм”* хэмээн тодорхойлсныг үгүйсгэн “хэлний хэрэглээний төрлийг тодорхойлогч - **соёл нь анхдагч**” хэмээн үзэж байв.

Нийгэм хэлшинжлэлийн тулгуур ойлголтууд

Орчин үед нийгэм хэлшинжлэлийн тулгуур ойлголтод хэлний хамтлаг, хэлний нөхцөл байдал, хэл – нийгмийн шүтэлцээ, хэлний харилцааны чадамж, хэлний тэмдгийн утгат томъёолол / *code* / , түүний өөрчлөгдөх үйл явц / *code-switching* / хос / зэргэд / хэлний асуудал/ *bilingualism, multilingualism* /, хэлний бодлого, төлөвлөлт, эх хэлний ариусал зэрэг асуудлыг багтаадаг. Эдгээр асуудлыг судлахдаа нийгмийн социаль бүтэц болон давхраажилын төлөөлөгчдийн хоорондоо ярилцах хэлэхүйн ялгарамж зэргийг хамруулан судалдаг. Нийгэм хэлшинжлэлийн гол хандлага нь хэлний үүсэн төлөвшил, хувьсал өөрчлөлт, хөгжлийн цаашдын хандлага зэргийг судлах явдал хэмээн тодорхойлдог. Энэхүү хандлага нь :

- **Хэл хийгээд нийгмийн шүтэлцээ** / хэл нь нийгмийн үзэгдэл /
- **Хэл оршин тогтнох ёрөнхий зүй тогтол / хэл бүрэлдэн тогтнох ,өөрчлөгдөн хувьсах хийгээд хөгжлийн ирээдүйн хандлага** гэсэн хоёр үндсэн чиглэлд хуваагддаг.Эл чиглэлтэй холбоотой хэлний хувьсал өөрчлөлт /*language changing*/,хэл соёлын – шүтэлцээ /*language and culture* /,үг яриа цээрлэх,ээрүүлэх ёсон / *taboo and euphemism* /,угсаатны хэл судлал / *language ethnomethodology* /,хэлний бодлого , төлөвлөлт / *language policy and planning* /зэргийг судалдаг.
Зарим судлаач “уг ш/у ны зангилаа асуудал нь хэлэхүйн ялгааг түлхүү судалдаг хэмээн үзвэл судалгааны гол чиглэл хэлний ялгарамжтай <*нөхцөлдсөн шинж*>хэмээн үзэж болно “хэмээн дүгнэдэг.[] Энэ нэр томъёо нь хэлний өөрчлөлттэй уялдаатай нийгмийн олон янзын хүчин зүйлийг хамардаг бөгөөд энэхүү хүчин зүйлийн нөлөө нь байнга өөрчлөгддөг боловч ихэнх тохиолдолд **илгээгч / sender /,хүлээн авагч / receiver /, нөхцөл байдал / setting /** гэсэн хүчин зүйлс голлодог.Үүнд:
- **Илгээгчийн / яригч этгээд /нийгмийн хамаарал** – энэ нь ярих үйлийн эзэн нийгмийн аль давхарганд хамаарах, ямар аялга илэрч байна гэдэгтэй холбоотой.Зарим судлаач эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондын хэлэхүйн ялгааг үүнд хамааруулдаг.[Фёрфи.1944]
- **Хүлээн авагч /сонсогч / этгээдийн нийгмийн хамаарал** – энэ нь өөрөөс нь ахимаг болон нийгмийн байр суурь дээгүүр хүмүүст хандахдаа эерүү найрсуу үг хэллэг ,аялга / *politeness*/хэрэглэдэг байна.Хүүхдийн хэл яриа болон насанд хүрэгсэд тэдэнтэй ярилцахдаа хэрэглэх үг яриа ,аялга зэргийг оруулдаг.[Фергюсон. 1964] Үүнд хамаатуулан судлах нэг төрөл нь биеийн хөгжлийн элдэв сэвтэй хүмүүстэй харьцахад нь ярианд нь илрэх өнгө аяс зэргийг судладаг.[Сепир]
- **Нөхцөл байдал/ setting /** – тухайн хувь хүний тодорхойлолтонд үл хамаарах харилцааны дам хүрээлэлд багтах боломжит бүхий л нөхцлийг хамруулдаг.
- Хам хийгээд цуваа цагийн тал – аливаа үзэгдлийг судлахдаа *хөдлөнги – тогтонги /* статик – динамик / гэсэн хосмогт судлахдаа тооцон үздэг цаг хугацааны хамаарал юм. Тодруулбал эл үзэгдлийг нийгэм хэлшинжлэлд **хам цаг** буюу / *synchrony/цуваа цаг* буюу / *diachrony* /гэсэн хэмжигдэхүүнд судалдаг.
- **Хэлний үйл байдал / behavior /**– хэлээ хэрхэн хэрэглэж ашиглаж байгаа онцлог ялгаа болон өөрийн , бусдын хэлний үйл байдлыг хэрхэн үнэлж буй зэрэг орно. Хэлний хэрэглэгдэхүүнийг *өргөмж, ердийн, доромж* зэрэг ямар хэв маягаар хэрэглэж байгааг судалдаг.
- **Хэлний тархацын цараа - /extent of diversity /**тухайн улс үндэстний нийгмийн давхраажил болон хэлэхүйн ялгарамж ,аялга зэргийг газар нутгийн тархацаар судлах чиглэл багтдаг.
- **Хэлний аж хэрэглээ** – хэрхэн хэрэглэж байгаа байдал болон түүний ялгаа зэргийг судална.Хэрэглэх гурван хэв шинжэд хуваан судалдаг.Үүнд: а/ социологчийн нүдээр судлах.Нийгмийн социаль бүтэц,эсвэл нийгмийн тодорхой нийтлэг үзэгдлийг илрүүлэн гаргах зорилго агуулан судалдаг.б/түүхэн хэлшинжлэлийн үүднээс судлах.Хэлний хувьсал өөрчлөлт ялгаатай нөхцөл байдалд хэрхэн явагдах,тухайлсан хэлний аялга, дэд аялга зэрэгт дээрх үзэгдэл адил хурдтай явагддаг эсэх зэрэг асуудлыг хэлний түүхийн баримтанд тулгуурлан судалдаг.в/ хэлний бодлого төлөвлөлт .Төрийн хэлний бодлого,төлөвлөлт хийгээд албан ёсны хэлний бодлого ,түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явц, эх хэлний бодлого ,хэлний хэм хэмжээг тодорхойлох зэрэг хамаарна.

Орчин үед хэрэглээний хэл шинжлэл нь нийгмийн амьдралд хэл хэрхэн нөлөөлдөг, хэлний сэтгэлгээний үүрэг,хэлний даяаршилын асуудал ,хэлний суртахуй зэрэг чиглэлд түлхүү хандаж байна.Нийгэм өөрчлөгдөх хувьсахын хэрээр хэлний өөрчлөгдөх зүй тогтлыг олж тогтохын тулд олон талын судалгаа хийж байна.Орчин үеийн нийгэм хэлшинжлэлийн судалгаанд дараах зарчмыг баримтлахыг судлаач **У.Лабов** дэвшүүлсэн байдаг.Үүнд:

- **Хуримтлуулах зарчим / the cumulative principle/** - хэлний талаарх ерөнхий мэдлэг , хэлний баримт ,түүнийг улам гүнзгийрүүлэн судлах хийгээд бусад салбарын судлаачдын бүтээж туурвисан арвин мэдлэгийг ашиглахыг чухалчилах .

- *Хэлбэр жигдлэх зарчим / the uniformation principle /* өөрсдийн оршин буй газар нутгийн хэлний үйл явц, баримтыг хам цаг */synchronic/* буюу тоочих, орчин цагийн болон хэлний хэрэглэгдэхүүнийг цуваа цагт */diachronic/* түүхэн үүднээс судлах зарчим юм.

- *Батлах зарчим /the principle of convergence /-* энэ нь шинжлэх ухааны судалгааны бусад салбарт шаардагдах хэлний баримтыг тухайлан судлах арга зам, хэлний түүхийн баримтанд тулгуурлан тайлбарлахдаа шинээр үүсэн гарч буй хэлний баримт сэлтийг тооцон үзэж ашиглах явдал юм.

Эрхиээлт өөрчлөлтийг тооцох зарчим / the principle of subordinate shift / ярилцагч этгээдийн хэл яриа, аялга зэрэг нь тухайн хэлний хэм хэмжээнээс ялгаатай байх, хэлний хувилбарт байдал, хэлний хэм хэмжээ, хувьсал өөрчлөлт зэрэг ялгааг олж судлах.

Хэлний найруулга өөрчлөгдөхийг тооцох зарчим / the principle of style-shifting / хэлэнд зөвхөн нэг л найруулга оршин байдаггүй, өгүүлэгч этгээд өөрийн дотоод сэтгэл хийгээд тухайн нөхцөл байдлаас хамаарч хэлний хэрэглэгдэхүүнийг ашигладаг.

Анхаарал хандуулах зарчим /the principle of attention / өгүүлэгч этгээд өөрийн хэл яриагаа тухайн нөхцөл байдалтай уялдуулан хянан, ”албан ёсны” хэл найруулгад захируулах зарчим

Эх хэлний зарчим / the vernacular principle / хэлний түүх болон бүтцийн өөрчлөлтийг аман ярианы онцлогт тулгуурлан судлах зарчим.

Хэлний тогтсон дүрэм баримтлах зарчим /the principle of formality/ тухайн хэлний үзэгдлийг хам бүтэцтэй нь уялдуулан тодорхойлох зарчим юм.

Энд дурдсан зарчим нь хэлний үзэгдлийг нийгмийн үзэгдэл хэмээн судлахад чухал ач холбогдолтой байдаг. Орчин цагт мэдээллийн асар их урсгалыг олон эх сурвалжаас байнга цацаж, хүлээн авч буй энэ үед хэлний найруулга, хэм хэмжээ байнга өөрчлөгдөж улмаар тэр бүрийг судалж зүй тогтлыг тогтооход дээрх зарчмыг баримтлах шаардлага урган гарч байна.

Ном зүй

1. Антони Гидденс Социологи Улаанбаатар 2006
2. Ammon, U. Code, sociolinguistic. In Ashler. 1994.
3. Bell, R. Sociolinguistics: Goals, Approaches and Problems. London 1973
4. Downes W Language and society Cambridge university press 2005
5. Мечковская .Н.Б. Социальная Лингвистика . М., 2000
6. Мөнхбат.О Социологийн онол Улаанбаатар 2008